



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2011 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 700


Улаанбаатар хот

Журам батлах тухай

МУИС-ийн дүрмийн 4.2.9.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргааны зөвлөлийн 2011 оны 11 дүгээр сарын 28, 12 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцэж сайшаагдсан "МУИС-ийн оюутны дадлагын ерөнхий журам"-ыг хавсралт 1 , "Сурган хүмүүжүүлэх дадлагын журам"-ыг хавсралт 2, "Байгалийн ухааны лабораторийн хичээл явуулах үйл ажиллагааны ерөнхий журам"-ыг хавсралт 3-аар баталсугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2003 оны 518, 665, 2005 оны 117 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Шинэчлэн батлагдаж буй эдгээр журмуудыг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг Бакалаврын сургалтын алба /Г.Цагаач/, бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалтын албаны эрхлэгч нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Д-р.Проф.С.ТӨМӨР-ОЧИР

Захирлын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
Эр... тоот тушаалын хавсралт

БАЙГАЛИЙН УХААНЫ ЛАБОРАТОРИЙН ХИЧЭЭЛ ЯВУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЖУРАМ¹


Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмыг байгалийн ухааны лабораторийн хичээлийг явуулахад баримтална.
- 1.2. Лабораторийн хичээлд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан, тусгайлан тоноглогдсон өрөө байранд явагдах оюутны тухайн шинжлэх ухааны онолын мэдлэгийг бататгаж, практик үйл ажиллагааны чадвар, дадал эзэмшүүлэх хичээлүүд хамаарагдана.
- 1.3. Лабораторийн хичээл нь үндсэн хичээлтэйгээ хамт, эсвэл тусдаа багц цагтай байна. Нэг багц цагийн хэмжээ нь 16 долоо хоногтой улирлын хувьд 48 цагтай тэнцүү байна.
- 1.4. Лабораторийн хичээлийг мэргэжлийн суурь, мэргэшүүлэх лабораторийн хичээл гэж ангилна.
- 1.5. Мэргэжлийн суурь лабораторийн хичээлийг сургалтын инженер, мэргэшүүлэх лабораторийн хичээлийг профессор, багш голлон хариуцаж заана. Мэргэжлийн суурь лабораторийн хичээлийг докторант оюутнаар заалгаж болно.
- 1.6. Мэргэжлийн суурь лабораторийн хичээл нь онолын мэдлэгийг бататгах хэсэгтэй, зааварчилгаагаар бүрэн хангагдсан, багаж хэрэгслийн холболт энгийн, тодорхой бөгөөд оюутанд туршилтын (таамаглал дэвшүүлэх, ажиглалт, хэмжилт хийх, үр дүнг боловсруулах, график байгуулах, тайлбарлах, дүгнэлт гаргах) энгийн арга зүйг эзэмшүүлэхэд чиглэсэн байна.
- 1.7. Мэргэшүүлэх лабораторийн хичээл нь багаж хэрэгсэл болон арга зүйн хувьд мэргэжлийн суурь лабораторийн хичээлээс ахисан түвшинд (аргачлал, багаж хэрэгсэл, урвалж бодисыг сонгох) байх ба бие даан туршилт хийж, дүгнэлт гаргах зэргээр оюутны сэтгэн бодох, бүтээлч чадварыг хөгжүүлэх зорилгыг агуулна. Энэ төрлийн лабораторийн хичээл нь оюутанд судалгааны ажил бие даан хийж сурах, шинжлэх ухааны эрэл хайгуул хийх, тухайн чиглэлээр хийгдсэн судалгааны орчин үеийн ажлууд, тэдгээрийн аргачлалтай танилцаж, давтан хийх, үр дүнг нарийн боловсруулж, зарим талаар шинэ үр дүнг гаргаж авахад шаардлагатай суурь арга барилыг эзэмшүүлэхэд чиглэнэ.
- 1.8. Лабораторийн хичээл нь хичээлийн хөтөлбөрөөс гадна гарын авлага/лабораторийн ажлын дэвтэртэй байна. Лабораторийн хичээлийн төрөл, зорилго, мэргэжлийн онцлогоос хамааруулан хичээлийн хөтөлбөрийг мэргэжлийн тэнхим/профессорын баг хариуцан боловсруулж, бүрэлдэхүүний сургуулийн Эрдмийн зөвлөлөөр батлуулан, мөрдүүлнэ. Лабораторийн хичээлийн батлагдсан хөтөлбөрийг хичээлийн жилийн эхэнд сургалтын мэдээллийн систем, "Оюутны гарын авлага"-д оруулна.
- 1.9. Бүрэлдэхүүн сургуулиуд шаардлагатай гэж үзвэл энэхүү журмаас гадна салбарынхаа онцлогийг тусгасан журмыг тусгайлан боловсруулж мөрдөж болно.

Хоёр. Лабораторийн хичээл явуулах орчин

- 2.1. Лабораторийн хичээлийг явуулахын тулд техникийн болон эрүүл ахуйн шаардлагад бүрэн нийцсэн гэрэл, ус, цахилгааны сүлжээ, агааржуулагч, техник хэрэгсэл (татах шүүгээ, ариутгалын шүүгээ гэх мэт), туршилт явуулах ширээ, сандал, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон бусад шаардлагатай зүйлээр хангагдсан орчныг бүрдүүлсэн байна.

¹ Захирлын 2003 оны 10 дугаар сарын 2-ний өдрийн 518 тоот тушаалаар батлагдсан журмын шинэчилсэн найруулга.



Гурав. Профессор, багш, сургалтын инженер ба хичээлийн туслах ажилтны үйл ажиллагааны уялдаа холбоо

3.1. Профессор, багш, сургалтын инженер нь лабораторийн хичээлд дараах нийтлэг үүрэгтэй оролцоно. Үүнд:

3.1.1. Лабораторийн хичээлийг удирдан явуулна:

- 3.1.1.1. Лабораторийн хичээлийн эхэнд хичээлийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны зааврыг оюутнуудад танилцуулан, шалгаж, гарын үсэг зуруулна.
- 3.1.1.2. Лабораторийн нэгж хичээлийн эхэнд тухайн лабораторийн ажлыг гүйцэтгэхэд оюутны мэдвэл зохих онолын мэдлэг, туршилтын дэс дараалал, багаж хэрэгслийг ажиллуулах талаарх ойлголт, бэлтгэлийг шалгаж, оюутанд туршилт хийх зөвшөөрөл олгоно.
- 3.1.1.3. Хичээлийн явцад байнгын хяналт тавьж, оюутанд зөвлөн туслана.
- 3.1.1.4. Оюутны лабораторийн ажлын гүйцэтгэлийн тайланг гарын авлага/лабораторийн ажлын дэвтэрт заасны дагуу тухай бүр шалгаж, зохих үнэлгээг өгнө.

3.1.2. Хичээлийн цагаар ажлын байрандаа байнга байх ба лабораторийн хичээлийг хяналтгүй орхихыг хориглоно. Хичээлийн цаг дууссаны дараа цахилгаан, гал, ус, хулгай зэрэг аюул осол, халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, өрөөг түгжин, лацдаж, хариуцсан хичээлийн туслах ажилтан, эсвэл харуулд хүлээлгэн өгнө.

3.1.3. Лабораторийн хичээлийн агуулга, бүтэц, хөтөлбөрийг боловсронгуй болгоход идэвх, санаачлагатай оролцоно.

3.2. Профессор, багш лабораторийн хичээлийг удирдан явуулахаас гадна дор дурдсан үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- 3.2.1. Лабораторийн ажлын зохиогч байж, холбогдох заавар, зөвлөмж, гарын авлага/лабораторийн ажлын дэвтэр, орчны стандарт болон үнэлгээний аргачлалыг боловсруулах буюу боловсруулахад оролцоно.
- 3.2.2. Шинээр лабораторийн ажил тавих, лабораторийн ажлыг байнга сайжруулж байх үүрэг хүлээнэ.
- 3.2.3. Сургалтын инженерийг дагуулан сургаж, түүний сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих ба шинээр тавьсан лабораторийн ажилтай холбоотой хүндрэл бэрхшээл, ажлын чанартай холбоотой асуудлыг бүрэн хариуцна.
- 3.2.4. Шинээр тавьсан лабораторийн ажлын эхний хичээлийг профессор, багш өөрөө удирдан явуулж, сургалтын инженерийг дагуулан сургана.

3.3. Сургалтын инженер нь лабораторийн хичээлд 3.1-д дурдсан үүргээс гадна дараах үүрэгтэй оролцоно. Үүнд:

- 3.3.1. Улирал эхлэхийн өмнө лабораторийн хичээлүүдийг явуулахад шаардлагатай багаж тоног төхөөрөмж, бодис урвалж, шил сав болон бусад эд зүйлийн жагсаалтыг зардлын тооцооны хамт гарган, хангалтыг хариуцан гүйцэтгэнэ.
- 3.3.2. Хариуцсан лабораторийг хичээлд бэлэн байлгана (хичээлд шаардлагатай багаж тоног төхөөрөмж, бодис урвалжийг бэлтгэх гэх мэт).
- 3.3.3. Лабораторийн эд хогшил, багаж төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцана:
 - 3.3.3.1. Хичээлд ашиглагдах бодис урвалж, шил сав, багаж тоног төхөөрөмжийг индексжүүлэн, төрөлжүүлж хадгална.
 - 3.3.3.2. Бодис урвалж, шил сав, багаж тоног төхөөрөмжийн хэрэглээний судалгааг тогтмол хийж, ашиглалтыг зохицуулна.

✓

- 3.3.3.3. Лабораторийн бодис урвалжийн хаягдал, уусмал бодисыг төрөлжүүлэн, индексжүүлж, зохих газарт нь хүлээлгэн өгнө.
- 3.3.3.4. Багаж, төхөөрөмжийн хөнгөн гэмтлийг засварлах ажлыг гардан хийнэ.
- 3.3.3.5. Багаж төхөөрөмжийн техникийн үйлчилгээг (тослох, цэвэрлэх, тохируулах зэрэг) зохих графикийн дагуу хийж, ациглалтын дэвтэр хөтөлнө.
- 3.3.4. Лабораторийн хичээлийн гарын авлага/лабораторийн ажлын дэвтрийг хүрэлцээтэй тоогоор хувиран, олшруулах ажлыг хариуцаж, оюутны бие даан суралцах төвд өгнө.
- 3.3.5. Улирлын эцэст хариуцсан лабораторийн үйл ажиллагааны тайланг бичиж тэнхим/профессорын багаар хэлэлцүүлж, бүрэлдэхүүний сургуулийн сургалтын албанд өгч, үнэлүүлнэ.
- 3.4. Профессор, багш лабораторийн хичээлд бэлтгэх, удирдан явуулахад хичээлийн туслах ажилтан туслах үүрэгтэй ба шаардлагатай тохиолдолд 3.3-д дурдсан үүргүүдийг гүйцэтгэнэ.
- 3.5. Бүрэлдэхүүн сургуулиуд салбарын онцлог, ажлын ачааллыг харгалзан хичээлийн туслах ажилтан, сургалтын инженерийн ажлын байрны тодорхойлолт дахь ажил үүргийн хуваарилалтад шаардлагатай зохицуулалтыг хийж болно.

*** **

ЛАБОРАТОРИЙН ХИЧЭЭЛИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1. Бүрэлдэхүүн сургууль лабораторийн хичээлийг зохион байгуулахдаа тусгайлан тоноглогдсон өрөө байранд профессор багш, сургалтын инженер, хичээлийн туслах ажилтан, оюутан аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байх ёстой.
2. Мэргэжлийн тэнхим/профессорын баг аюулгүй ажиллагааны дор дурдсан нийтлэг шаардлагуудыг тусган, лабораторийн хичээлийн орчин, хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмж, бусад хэрэгсэл, осолд хүргэж болзошгүй хүчин зүйлс зэрэг онцлогийг харгалзсан, хичээлд оролцогч талуудын мөрдвөл зохих аюулгүй ажиллагааны тодорхой зааврыг боловсруулж, лабораторийн хичээлийн хөтөлбөрт тусгана.
3. Хичээлийг удирдах профессор багш/сургалтын инженер хичээлийн эхэнд аюулгүй ажиллагааны зааврыг оюутнуудад танилцуулж, гарын үсэг зуруулан, баталгаажуулсан байна. Аюулгүй ажиллагааны заавартай танилцаагүй оюутныг лабораторийн хичээлд оролцуулахыг хориглоно.
4. Лабораторид оюутан ганцаараа лабораторийн ажил, туршилт шинжилгээ хийхийг хориглоно. Лабораторийн хичээлийг профессор багш/сургалтын инженер лабораторийн хичээлийн туршид оюутны дэргэд байна.
5. Аюулгүй ажиллагааны зааварт лабораторийн хичээлийг удирдах багш, оюутны мэдвэл зохих дараах зүйлсийг тодорхой тусгасан байна. Үүнд:
 - 5.1 Нэгж хичээл бүрийн өмнө оюутан тухайн лабораторийн ажлын заавар, хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, зориулалт, ашиглах заавартай сайтар танилцаж, чанд мөрдөнө.
 - 5.2 Лабораторийн хичээлийг удирдах профессор багш/сургалтын инженерийн зөвшөөрлөөр лабораторийн ажлыг эхэлнэ.
 - 5.3 Аюулгүй ажиллагааны зааврыг судлахгүйгээр, мөн лабораторийн ажилтай холбоогүй туршилт шинжилгээ хийхийг хориглоно.
 - 5.4 Аюулгүй ажиллах, аюулаас урьдчилан сэргийлэх арга барил эзэмшсэн, аюул тохиолдсон үед түүний хор хөнөөлийг яаралтай зайлуулах арга хэмжээг авахад суралцсан байна.
 - 5.5 Лабораторийн хичээлийн үед ажиллах орчиндоо хэрэглэх багаж, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг зөв дэс дараалал, эмх цэгцтэй байршуулна.
 - 5.6 Хичээлийн үед бусдад саад болохоор чимээ шуугиан гаргах, багш, оюутныг цочоох, сандраах, бусдын анхаарлыг өөр зүйлд татах зэрэг зүй бус байдал гаргахыг хориглоно.
 - 5.7 Лабораторид тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэх, идэж уухыг хориглоно.
 - 5.8 Шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэглэл /нүдний шил, бээлий гэх мэт/-ийг бэлтгэж, хэрэглэнэ.
 - 5.9 Хичээлийн үед цэвэрч байдлыг эрхэмлэн, ажил дууссаны дараа бүх зүйлийг зохих шаардлагын дагуу хурааж, цэвэрлэнэ.
 - 5.10 Аюул, осол тохиолдсон үед хэрэглэх нэн шаардлагатай эм, ороох боох материал, ариун цэврийн хэрэглэл бүхий эмийн сан хаана байгаа, хэрхэн хэрэглэх тухай мэдсэн байх.
6. Аюулгүй ажиллагааны зааврыг лаборатори бүрт ил харагдахуйц газар хадсан байна.

